



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 248

Улаанбаатар хот

Хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор
батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д дор дурдсан агуулгатай 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 10.1.16 дахь заалтыг нэмсүгэй.

“10.1.16. зээлийн өрийн үлдэгдлийн дэлгэрэнгүй тайлан /Хавсралт 16/;”

2. Мөн журмын 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

"5.5. Дараах ББСБ-ын хувьд энэхүү үзүүлэлтийг тооцох шаардлагагүй буюу хангаж ажилласан гэж үзнэ. Үүнд:

5.5.1. гадаад валютаар бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлээгүй бөгөөд гадаад валютаар илэрхийлэгдэх актив хөрөнгөгүй;

5.5.2. зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаа явуулж буй;

5.5.3. зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй.

3. Олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000871